



Долоо хоног тутмын хэвлэл  
2016 оны 12 дугаар сарын 08  
№ 45 /954/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын  
хууль

2254

Монгол Улсын  
Их Хурлын  
тогтоол

2254

Монгол Улсын  
Ерөнхийлөгчийн  
зарлиг

2262

**Дэлхийн худалдааны  
байгууллага байгуулах тухай  
Марракешийн хэлэлцээрт  
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай  
протоколд нэгдэн орох тухай**

**Төрөөс мөнгөний бодлогын  
талаар 2017 онд баримтлах  
үндсэн чиглэл батлах тухай**

**Засгийн газарт чиглэл  
өгөх тухай**



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

798. Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай  
Марракешийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт  
оруулах тухай протоколд нэгдэн орох тухай 2254

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

799. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд  
баримтлах үндсэн чиглэл батлах тухай Дугаар 68 2254
800. Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль  
батлагдсантай холбогдуулан авах зарим арга  
хэмжээний тухай Дугаар 69 2256
801. Санхүүгийн зохицуулах хорооны гишүүнийг  
томилох тухай Дугаар 72 2258
802. Санхүүгийн зохицуулах хорооны гишүүний  
үүрэгт ажлаас чөлөөлөх тухай Дугаар 73 2259
803. Олон нийтийн радио, телевизийн Үндэсний  
зөвлөлийн гишүүнээр томилох тухай Дугаар 74 2259
804. Олон нийтийн радио, телевизийн Үндэсний  
зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх тухай Дугаар 75 2260

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

805. Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох  
тухай Дугаар 155 2260
806. Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох  
тухай Дугаар 156 2261
807. Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох  
тухай Дугаар 157 2261
808. Засгийн газарт чиглэл өгөх тухай Дугаар 158 2262

### МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

809. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн  
15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг Монгол  
Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг  
зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн  
тухай Дугаар 12 2263



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 11 дүгээр  
сарын 24-ний өдөр

Улаанбаатар  
хот

### **ДЭЛХИЙН ХУДАЛДААНЫ БАЙГУУЛЛАГА БАЙГУУЛАХ ТУХАЙ МАРРАКЕШИЙН ХЭЛЭЛЦЭЭРТ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ПРОТОКОЛД НЭГДЭН ОРОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Марракешийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколд Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр нэгдэн орсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Марракешийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протокол хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 11 дүгээр  
сарын 17-ны өдөр

Дугаар 68

Улаанбаатар  
хот

### **Төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах үндсэн чиглэл”-ийг хавсралтаар баталсугай.

2. Эдийн засгийн хүндрэлийг даван туулах, банкны тогтолцооны эрсдэл даах чадварыг сайжруулах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/, Монголбанк /Н.Баяртсайхан/-нд үүрэг болгосугай.

3. Доор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/, Монголбанк /Н.Баяртсайхан/, Санхүүгийн зохицуулах хороо /С.Даваасүрэн/-нд тус тус даалгасугай:

1/валютын дотоодын захын дэд бүтцийг хөгжүүлж, ил тод, үр ашигтай байдлыг хангасан шинэ тогтолцоо бүрдүүлэх;



2/санхүүгийн салбарын эрсдэлийг бууруулах арга хэмжээний хүрээнд активын удирдлагын мэргэшсэн институцийн эрх зүйн орчныг бүрдүүлэх;

3/санхүүгийн зах зээлийн үр өгөөжийг нэмэгдүүлэн, шударга өрсөлдөөнийг дэмжих, ил тод байдлыг сайжруулах зорилгоор банкаас бусад оролцогчийн үйл ажиллагаа, суурийг тэлж төрөлжүүлэх, шаардлагатай эрх зүйн орчныг шинэчлэх;

4/мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх эрх зүйн зохицуулалтыг олон улсын стандартад нийцүүлэн боловсронгуй болгох;

5/эдийн засгийн идэвхжилийг дэмжих, банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний өртгийг бууруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор дотоодын банкны тогтолцоог хамгаалах, гадаадын банк, түүний салбар нэгж болон бусад төрөлжсөн банкны үйлчилгээг нэвтрүүлэх боломжийг судалж, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;

6/орон сууцны санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгон хөгжүүлэх, ипотекийн зээлийн хөтөлбөрийг макро эдийн засгийн төлөв байдалтай уялдуулан урт хугацаанд хэрэгжих боломжийг бүрдүүлэх.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Д.Тэрбишдагва/-нд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

Монгол Улсын Их Хурлын 2016 оны  
68 дугаар тогтоолын хавсралт

**ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН  
ТАЛААР 2017 ОНД БАРИМТЛАХ  
ҮНДСЭН ЧИГЛЭЛ**

Мөнгөний бодлого нь улс орны хэмжээнд үүсээд байгаа эдийн засгийн хүндрэлийг хохирол багатайгаар даван туулж, макро эдийн засгийг богино хугацаанд тогтворжуулан эдийн засгийн дунд, урт хугацааны тогтвортой өсөлтийг хангах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

**1.Мөнгөний бодлогын зорилтын хүрээнд:**

1.1.Мөнгөний бодлогын зах зээлд суурилсан хэрэгслийг ашиглан хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2017-2019 онд жилийн 8 хувиас дээшгүй түвшинд байлгана.



1.2.Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэн, уян хатан тогтох зарчмыг баримтална.

1.3.Эдийн засгийн гадаад орчинд гарч болзошгүй огцом өөрчлөлтийг төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн уян хатан бодлого, мөнгөний бодлогын арга хэрэгслүүдийг ашиглан зохицуулж, гадаад валютын улсын нөөцийг зохих түвшинд хүргэн нэмэгдүүлнэ.

## **2.Санхүүгийн салбарын тогтвортой байдлын хүрээнд:**

2.1.Санхүүгийн салбарын эрсдэлийг бууруулах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор системийн тогтвортой байдлын үнэлгээг олон улсын санхүүгийн байгууллагатай хамтран гүйцэтгэж, макро зохистой бодлогыг хэрэгжүүлнэ.

2.2.Банкны салбарын төлбөр түргэн гүйцэтгэх болон эрсдэл даах чадварыг хадгалах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

## **3.Санхүүгийн зах зээлийн дэд бүтэц, түүний институцийг бэхжүүлэх хүрээнд:**

3.1.Эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулах үүднээс Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааг идэвхижүүлж, зөвлөлийн гишүүдийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

3.2.Монголбанкны бие даасан, хараат бус байдал, валют, үндэсний төлбөр тооцооны системийн зохицуулалтыг боловсронгуй болгоно.

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2016 оны 11 дүгээр  
сарын 17-ны өдөр

Дугаар 69

Улаанбаатар  
хот

### **Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.17 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явцад хууль, эрх зүйн орчныг сайжруулах, төсвийн орлогыг нэмэгдүүлэх, төсвийн зардлыг хэмнэх, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын менежментийг сайжруулах талаар дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т даалгасгай:



1/Хууль, эрх зүйн орчныг нь сайжруулах чиглэлээр дараахь асуудлыг судалж, саналаа Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх:

1.бэлэглэлийн гэрээг ашиглан татвар төлөхөөс зайлсхийхээс урьдчилан сэргийлэх зорилгоор бэлэглэлийн гэрээний бүртгэл болон бүртгэлийн байгууллага, нотариатын байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулах;

2.татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг багасгах боломж;

3.хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх;

4.төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэгтэй давхацсан үйл ажиллагаа эрхэлдэг Засгийн газрын тусгай сангуудыг татан буулгах;

5.төсвийн шатлал бүрд төсвийн орлого, зарлагыг бодитой тооцох аргачлал бий болгох, төсвийн төслийг боловсруулахад баримтлах зарчмыг оновчтой тогтоох, хэлэлцэн батлах, төсвийн хэрэгжилт, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах талаар бодлогын цогц арга хэмжээ авах;

6.орон нутгийн төсвийн суурь зарлагыг тооцох аргачлал, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх үйлчилгээний стандарт, тэдгээрийн орцын болон төсвийн нормативыг хянан үзэж, шинэчлэн батлах.

2/Төсвийн орлого нэмэгдүүлэх чиглэлээр:

1.коксжих нүүрсний экспортын үнийг дэлхийн зах зээлийн үнийн түвшинтэй нийцүүлэх, нэгдсэн нэг үнээр экспортод гаргах бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2.түүхий нефтийн экспортоос нөөц ашигласны төлбөрийг тооцож авах, борлуулалтын орлогыг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх хуулийн шаардлагыг бүтээгдэхүүн хуваах гэрээнд тусгах гэрээ хэлцлийг хийж, дүнг Улсын Их Хуралд танилцуулах.

3/Төсвийн зардал хэмнэх чиглэлээр:

1.төрийн албан хаагчдын тоог 2017 оны төсвийн жилд нэмэгдүүлэхгүй байх;

2.Засгийн газрын тусгай сангуудын авлагыг барагдуулах, тусгай сан тус бүрийн хөрөнгийн зарцуулалтын үр өгөөжийг тооцох, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Тариаланг дэмжих сангийн хөрөнгийн бодит өгөөж, ажлын байр нэмэгдүүлсэн байдал, үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, бүтээгдэхүүний тоо хэмжээ, экспортод үзүүлсэн үр дүн, нөлөөллийн талаар судалгаа хийж, дүнг Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд танилцуулах;



3.гадаад зээллэгийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлсэн зээл тус бүрийг үнэлэх, мөн зориулалтын бусаар ашигласан, хугацаа хэтэрсэн зэрэг зөрчилтэй зээлүүдийг эргэн төлүүлж, үүссэн авлагыг барагдуулах;

4.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн менежментийг сайжруулах чиглэлээр:

1.улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн орлогыг нэмэгдүүлэх;

2.2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар баталгаажсан 10.8 их наяд төгрөгийн өглөгийг бууруулах;

3.төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн зардлыг багасгах, тэдгээрт ажиллагсдын тоог бууруулан 2012 оны түвшинд хүргэх;

4.төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төлөөлөл голлон ордог зарчимд шилжих;

5.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, удирдлагын цалин, урамшууллыг оновчтой тогтоох.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо /Ч.Хүрэлбаатар/-нд, тогтоолын 1.3.2 дахь дэд заалтад хяналт тавьж ажиллахыг Төсвийн зарлагын хяналтын дэд хороо /З.Нарантуяа/-нд тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолыг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2016 оны 12 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 72

Улаанбаатар  
хот

### **Санхүүгийн зохицуулах хорооны гишүүнийг томилох тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах



хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр Нямандэлэгийн Мандуулыг томилсугай.

2.Энэ тогтоолыг 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2016 оны 12 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 73

Улаанбаатар  
хот

**Санхүүгийн зохицуулах хорооны  
гишүүний үүрэгт ажлаас  
чөлөөлөх тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тул Жалцангийн Цэдэнрагчааг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2016 оны 12 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 74

Улаанбаатар  
хот

**Олон нийтийн радио, телевизийн  
Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэг, Олон нийтийн радио, телевизийн тухай





хуулийн 21 дүгээр зүйлийн 21.8 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Хайдавын Чилаажавыг олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилсугай.

2.Энэ тогтоолыг 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

### **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2016 оны 12 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 75

Улаанбаатар  
хот

#### **Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэг, Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Аюушийн Мөнхбатыг олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

### **МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2016 оны 11 дүгээр  
сарын 29-ний өдөр

Дугаар 155

Улаанбаатар  
хот

#### **Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14



дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Йорданы Хашимитын Вант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Банзрагчийн Одонжилийг эгүүлэн татаж, Йорданы Хашимитын Вант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Чулууны Баярмөнхийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН  
ЭЛБЭГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2016 оны 11 дүгээр  
сарын 29-ний өдөр

Дугаар 156

Улаанбаатар  
хот

**Элчин сайдыг эгүүлэн татах,  
тохоон томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Ливан Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Банзрагчийн Одонжилийг эгүүлэн татаж, Бүгд Найрамдах Ливан Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Чулууны Баярмөнхийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН  
ЭЛБЭГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2016 оны 11 дүгээр  
сарын 29-ний өдөр

Дугаар 157

Улаанбаатар  
хот

**Элчин сайдыг эгүүлэн татах,  
тохоон томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:



Монгол Улсаас Бүгд Найрамдах Армян Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Шүхэрийн Алтангэрэлийг эгүүлэн татаж, Бүгд Найрамдах Армян Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Банзрагчийн Дэлгэрмааг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН  
ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2016 оны 12 дугаар  
сарын 02-ны өдөр

Дугаар 158

Улаанбаатар  
хот

### Засгийн газарт чиглэл өгөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 12 дугаар зүйлийн 12 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Нэг. Хөрс хамгаалах, хөрсний доройтлыг бууруулах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх, энэ чиглэлээр төрийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах, иргэд, аж ахуйн нэгжийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлж, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Ж.Эрдэнэбат)-т чиглэл болгосугай:

1. Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд судалгаа хийж хуулиудын хэрэгжилтийг хангах, эрчимжүүлэх, шинэчлэх;

2. Суурьшлын бүс, тариалангийн болон бэлчээрийн хөрсний доройтолд дүгнэлт гаргаж хөрс, бэлчээрийг хамгаалах, нөхөн сэргээх богино, дунд, урт хугацааны бодлогын нэгдсэн хөтөлбөр боловсруулан батлах, хэрэгжүүлэх;

3. Хөрс, бэлчээрийн мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгож, жил бүр бүртгэх;

4. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон бэлчээр ашиглах уламжлалт арга ажиллагааны дэвшилтэт хэлбэрийг хэрэгжүүлж, хөрс бэлчээр сайжруулах дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх;

5. Хөрс, бэлчээр хамгаалах, нөхөн сэргээхэд чиглэсэн арга хэмжээнд зарцуулах зардлыг 2019 оноос эхлэн жил бүр орон нутгийн төсөвт тусгаж хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, хяналт тавих;

6. Хөрс хамгаалах үндэсний өдөртэй болох;

Хоёр. “Хөрс хамгаалах өдөр” уул уурхай, газар тариалан, мал аж ахуй эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд холбогдох төрийн



болон мэргэжлийн байгууллагатай хамтран хөрс хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр ажил зохион байгуулж, тэдгээрт дэмжлэг үзүүлэн хамтран ажиллахыг нийт иргэд, төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагад уриалсугай.

Гурав. Зарлигийн биелэлтийн талаар Монгол Улсын Ерөнхийлөгч болон олон нийтэд тайлагнаж байхыг Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН  
ЭЛБЭГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**ЖАРГАЛТУЛГЫН  
ЭРДЭНЭБАТ**

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2016 оны 12 дугаар  
сарын 02-ны өдөр

Дугаар 12

Улаанбаатар  
хот

**Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн  
15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг Монгол Улсын  
Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх  
маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны  
танхим 11.30 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Жанцан даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Т.Лхагваа, Д.Сугар, Д.Солонго /илтгэгч/, Д.Ганзориг нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Ч.Жадамба, Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар нар оролцлоо.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор шүүгчдийнх нь дотроос Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар нэг удаа томилно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор гишүүдийнх нь дотроос зургаан жилийн хугацаагаар Ерөнхийлөгч томилно.” гэснийг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.



**Нэг. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 15 дугаар хорооны оршин суугч, иргэн Ч.Жадамба Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэлдээ:**

“1. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор шүүгчдийнх нь дотроос Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар нэг удаа томилно.” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор гишүүдийнх нь дотроос зургаан жилийн хугацаагаар Ерөнхийлөгч томилно.” гэж заасныг илэрхий зөрчжээ. Үндсэн хуулийн заалтаас үзвэл Монгол Улсын Ерөнхийлөгч, Үндсэн хуулийн цэцийн дарга нарт Монгол Улсын Үндсэн хуулиар дахин томилогдох болон сонгогдох давтамж, хязгаарыг зааж өгсөн байх бөгөөд харин бусад албан тушаалтанд энэ хязгаар хамааралгүй байна. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуульд тусгагдсан нэр бүхий албан тушаалтныг дахин томилох, сонгох тухай хязгаарлалт нь зөвхөн Үндсэн хуулиар тодорхойлогдох бөгөөд Үндсэн хуулиас бусад хууль энэ хязгаарлалтыг агуулах нь Үндсэн хуулийг шууд зөрчих агуулгатай байна.

2. Монгол Улсын иргэн Д.Ламжав, Ц.Батхолбоо нар 2016 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлээр өөрчлөлт оруулсан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандаж Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Цэцийн есөн гишүүний гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилох бөгөөд Цэцийн гишүүнийг нэг удаа улируулан томилж болно.” хэмээн нэмэлт оруулсан байна. Дээрх нэмэлт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.” түүнчлэн Жаран дөрөвдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана.” гэсэн заалтыг зөрчсөн байна. Өөрөөр хэлбэл, Улсын Их Хурал Үндсэн хуулиас давсан хязгаарлалтыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд оруулсан хэмээн үзэж байна.” гэсэн агуулга бүхий мэдээлэл гаргасныг Үндсэн хуулийн цэц 2016 оны 2 дугаар сарын 15-ны өдөр хуралдаж 03 дугаартай дүгнэлт гарган шийдвэрлэсэн байх бөгөөд уг дүгнэлтийн “Үндэслэх” хэсгийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Цэцийн гишүүнийг нэг

удаа улируулан томилж болох заалт оруулсан байна. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт зөвхөн Үндсэн хуулийн цэцийн даргыг нэг удаа улируулан сонгож болохоор заасан атлаа Цэцийн гишүүнийг дахин томилогдоход хязгаарлалт тавиагүй байна. Үүнээс үзэхэд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар Цэцийн гишүүний дахин томилогдох хугацаанд хийсэн хязгаарлалт нь Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулж байна.” хэмээн дурдаж, мөн дүгнэлтийнхээ 1 дэх хэсэгт дээрх заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн байна гэж дүгнэжээ. Улмаар уг маргааныг Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 2016 оны 6 дугаар сарын 17-ны өдөр Их суудлын хуралдаанаараа хэлэлцэж, маргаан бүхий хуулийн холбогдох хэсгийг хүчингүй болгож шийдвэрлэжээ. Өөрөөр хэлбэл, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэгт заасан “Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор шүүгчдийнх нь дотроос Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар нэг удаа томилно.” гэсэн заалт нь өмнө нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэрлэсэн маргаантай агуулгын хувьд адил бөгөөд жишиг болохуйц бодит баримт юм.

3. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг нь Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчээр томилогдохоор санал болгож буй нэр дэвшигчийн болон Улсын дээд шүүхийн, цаашлаад Монгол Улсын Ерөнхийлөгчийн Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхэд ердийн хуулиар хязгаарлалт тавьж буй явдал бөгөөд энэ агуулгаараа Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй байна.

Иймд Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн болон түүнийг зөрчсөн эсэхийг хянан шийдвэрлэж, хүчингүй болгож өгөхийг хүсье.” гэсэн байна.

***Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:***

“1.Үндсэн хуулийн улируулан сонгох асуудлын тухайд, Үндсэн хуульд улируулан сонгох, томилох боломжтой төрийн өндөр албан тушаалтны эрхийг тусгайлан зохицуулж заасан байна. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин нэгдүгээр зүйлийн 7 дахь хэсэгт Ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаа улируулан сонгож болохоор, Жаран тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт Үндсэн хуулийн цэцийн даргыг нэг удаа улируулан сонгохоор тус тус тодорхой зохицуулжээ.Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор гишүүдийнх нь дотроос зургаан жилийн хугацаагаар



Ерөнхийлөгч томилно.”, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэгт “... Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар томилно.”, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор шүүгчдийнх нь дотроос Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар нэг удаа томилно.” гэж заасан нь Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг нэг удаа зургаан жилийн хугацаатай томилох бөгөөд улируулан томилох тухай асуудал Үндсэн хуульд тусгалаа олоогүй байна. Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх заалтын агуулгын хүрээнд Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэгт зааснаар “Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор шүүгчдийнх нь дотроос Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар нэг удаа томилно.” гэж хуульчлан бэхжүүлсэн байна.

2. Хууль дээдлэх зарчмыг баримтлах тухайд, Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн хяналтын шатны 2014 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн шүүх хуралдаанаар аймгийн Ерөнхий аудиторыг улируулан томилох талаарх иргэн О.Ганболдын нэхэмжлэлийг хянаж үзээд 89 дүгээр тогтоол гаргажээ. Уг тогтоолд “Төрийн үйл ажиллагаанд хууль дээдлэх зарчмын үүднээс төрийн байгууллага, албан тушаалтан хуулиар олгогдоогүй эрхийг хэрэгжүүлэхгүй тул төрийн албаны хугацаатай томилогддог албан тушаалтны бүрэн эрхийн хугацаа дуусахад улируулан томилж болохоор хуульд тусгайлан заагаагүй бол томилох эрх бүхий этгээдэд уг албан тушаалтныг “улируулан томилох эрх олгогдоогүй гэж үзнэ” гэсэн нь жишиг болохуйц бодит баримт гэж үзэж байна.

3. Албан тушаалыг адилтган авч үзэх онолын тухайд, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг Үндсэн хуулийн цэцийн гишүүний албан тушаалтай адилтган авч үзэх нь онол арга зүйн хувьд үндэслэлгүй байна. Учир нь Монгол Улсын шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлэх бөгөөд шүүх эрх мэдлийг өөр байгууллага хэрэгжүүлдэггүй. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг зөвхөн гишүүдийнх нь дотроос Ерөнхийлөгч томилдог. Улсын дээд шүүхийн шүүгч нь хууль зүйн дээд боловсролтой, албан ёсны зөвшөөрөл авсан байхаас гадна, түүнд Үндсэн хуулийн цэцийн гишүүнтэй адил хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй байх шалгуур, шаардлага тавигддаггүй. Түүнчлэн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч нь шүүгч байх хугацаандаа томилогддог тул эдгээр албан тушаалтнуудыг адилтган авч үзэх нь үндэслэлгүй байна.

Иймд иргэн Ч.Жадамбын мэдээлэлдээ дурдсан Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг Монгол

Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "...Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор гишүүдийнх нь дотроос зургаан жилийн хугацаагаар Ерөнхийлөгч томилно." гэснийг зөрчөөгүй гэж үзэж байна." гэсэн байна.

#### **ҮНДЭСЛЭЛ:**

1. Монгол Улсын Үндсэн хуульд заасан албан тушаалтнуудаас зөвхөн Ерөнхийлөгч болон Үндсэн хуулийн цэцийн даргыг нэг удаа улируулан сонгож болохоор тусгайлан хуульчилсан байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн бүрэн эрхийн хугацаа зургаан жил байхаар хуульчилсан бөгөөд түүнийг улируулан томилох эсэх асуудалд Үндсэн хуулиарливаа хязгаарлалт тогтоогоогүй байна.

Гэтэл Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэгт "Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор шүүгчдийнх нь дотроос Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар нэг удаа томилно." хэмээн заажээ. Ийнхүү Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг зөвхөн нэг удаа томилох агуулгаар хуульчилсан хязгаарлалт нь Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн холбогдох заалтыг явцууруулсан гэж үзэх үндэслэлтэй байна.

3. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 03 дугаар дүгнэлт, 04 дүгээр тогтоолоор уг маргаантай агуулгын хувьд адил маргааныг шийдвэрлэсэн байна. Дээрх шийдвэрийн үндэслэлд "Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт зөвхөн Үндсэн хуулийн цэцийн даргыг нэг удаа улируулан сонгож болохоор заасан атлаа Цэцийн гишүүнийг дахин томилогдоход хязгаарлалт тавиагүй байна. Үүнээс үзэхэд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар Цэцийн гишүүний дахин томилогдох хугацаанд хийсэн хязгаарлалт нь Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулж байна." гэжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

#### **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:**

1. Монгол Улсын Их Хурлаас 2012 оны 3 дугаар сарын 7-ны өдөр баталсан Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн "Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор шүүгчдийнх нь дотроос Ерөнхийлөгч зургаан жилийн





хугацаагаар нэг удаа томилно.” гэсэн заалтын “... нэг удаа ...” гэсэн хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор гишүүдийнх нь дотроос зургаан жилийн хугацаагаар Ерөнхийлөгч томилно.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Монгол Улсын Их Хурлаас 2012 оны 3 дугаар сарын 7-ны өдөр баталсан Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэгт” Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор шүүгчдийнх нь дотроос Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар нэг удаа томилно.” гэсний “... нэг удаа ...” гэсэн заалтын үйлчлэлийг 2016 оны 12 дугаар сарын 2-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

3. Энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**ДАРГАЛАГЧ**

**Н.ЖАНЦАН**

**ГИШҮҮД**

**Т.ЛХАГВАА**

**Д.СУГАР**

**Д.СОЛОНГО**

**Д.ГАНЗОРИГ**

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 1

**Индекс: 14003**